

ЯПОН СУДЛАЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЗОРИЛТ

Б.Сэржав

Монгол Японы хооронд дипломат харилцаа тогтосноос хойш 30 жил өнгөрлөө. Энэ хугацаанд хоёр орны харилцаа хамтын ажиллагаа бүх салбарыг хамран хөгжиж, эдүгээ Япон улс манай улсын гадаад харилцаанд чухал байр суурийг эзэлсэн гол түнш орон боллоо. Монгол Японы харилцааг өмнөх ололт амжилтыг улам бататган бэхжүүлэх замаар XXI зуунд иж бүрэн түншлэлийн хэмжээнд хүргэн хөгжүүлэх зорилтыг хоёр орны төр засгийн тэргүүн нарын удаа дараагийн уулзалтаас дэвшүүлэн тавьсан билээ.

Хоёр орны найрсаг харилцаа, хамтын ажиллагаа эрчимтэй хөгжихийн хирээр Монгол, Японы ард түмний хоорондын харилцан ойлголцол, итгэлцэл өсөн дээшилж байна. Үүнтэй уялдан хоёр орны ард түмний бие биеийг харилцан сонирхох, танин мэдэх, улам өргөн хүрээнд ажил хэрэгчээр хамтран ажиллах, харилцан суралцах хүсэл сонирхол өдрөөс өдөрт нэмэгдэж ирлээ. Улс төр, эдийн засгийн болон бусад салбарын өргөн хамтын ажиллагаа, өргөн олон нийтийн найрсаг дотно харилцаа нь манай улсад Япон судлалыг эрчимтэй хөгжүүлэх, ард түмэндээ Япон орныг үнэн зөвөөр ойлгуулах бодит шаардлагыг бий болгож байгаа юм.

Монгол улсын зах зээлийн эдийн засгийн шинэ нөхцөл байдал Японы хөгжлийн туршлага сургамжаас бүтээлчээр суралцах, улс орныхоо хөгжлийг түргэтгэхэд түүнийг оновчтойгоор ашиглах, тусламж дэмжлэг авах зэрэг хөгжил дэвшлийн амин чухал зангилаа асуудлуудтай япон судлалын ажил салшгүй холбоотой юм. Тухайлан дайнаас хойших Японы улс төр, эдийн засгийн бодлого, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, бүтцийн өөрчлөлт, хөгжлийн замд тохиолдсон саад бэрхшээл, өндөр хөгжлийн үр дүн, уршиг, өнөөгийн эдийн засгийн хүндрэл, энэ бүхнийг Монгол улсын хөгжлийн чиг баримжааг бодолцон тал бүрээс нь ул үндэстэй нягтлан судлах явдал өнөөгийн нөхцөлд чухал болоод байна. Нэгэн зэрэг Япон судлалын ажлыг түүх, соёл иргэншлийн үүднээс гүнзгий явуулах нь гарал үүсэл, угсаатны хувьд холбоотой, харилцан бие биедээ нэн элэгсэг дотно

Б.Сэржав - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

ханддаг, царай төрх, зан заншил, хэлний хувьд ойролцоо шинж төрх Монголчууд, бидний хувьд ихээхэн сонирхолтой, ирээдүйтэй судалгааны шинэ чиглэл бий болгож байна.

Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи Япон судлалд онцгой анхаарал тавьж 1999 онд Олон улс судлалын хүрээлэнгийн шинэ зохион байгуулалтаар энэ ажлыг гүйцэтгэх шинжилгээ судалгааны бие даасан нэгж болох Япон судлалын секторыг байгуулан ажиллуулсан билээ. Энэ нь тус хүрээлэнгийн эрдэм шинжилгээний сэдэвт ажлын хүрээнд явуулж ирсэн Япон судлалын ажлын уламжлалыг бататгаж, уг судалгааг өргөтгөн урагш ахиулахад чиглэсэн чухал ач холбогдолтой үйл явдал болсон юм.

Япон судлалын ажлын уламжлалыг Монгол улсын ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн (Дорнодахины судлалын хүрээлэн, Ази, Африкийн хэлтэс)-д үндэс суурь нь тавигдан, гадаад орон судлалын шинэ салбар үүсч бий болсон 60, 70-аад оноос эхлэн авч үзэж болох талтай. Тэр үеэс хойш өнөөдрийг хүртэл Япон судлал хүрээлэнгийн судалгааны ажлын нэгэн гол чиглэл болж ирлээ.

1970-80-аад онд Дорнодахины судлалын хүрээлэнд анхааран судалж байсан гол сэдвүүдийн нэг нь Япон улс дахь Монгол судлал байлаа. Япон улс Монгол судлалыг XX зууны эхэн үеэс түүх, улс төр, нийгэм, эдийн засаг, хэл, соёл, утга зохиол, боловсрол гэх мэт олон салбарт хөгжүүлж, монгол судлалаар дэлхийд тэргүүлэх байранд гарч ирсэн билээ. Япон дахь Монгол судлалын ололт амжилт нь манай улсад Япон судлалыг үүсгэн хөгжүүлэхэд тодорхой нөлөө үзүүлсэн юм. Эхний үед Япон улсад хийгдэж буй монгол судлалын ажил, Японы эрдэмтдийн туурвисан манай улсын холбогдолтой гол гол бүтээлүүдийг судлан танилцуулах ажлыг хийж байв. “Хятад, Япон дахь Монгол судлал” хамтын бүтээл /УБ. 1988/ хэвлэгдэн гарсан нь дээрх судалгааны анхны үр дүн болсон юм.

80-аад оны үед Дорнодахины судлалын хүрээлэнг япон хэлтэй боловсон хүчнээр бэхжүүлэх, залуу судлаачдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх талаар ихээхэн анхаарал тавьж байлаа. Хүрээлэн япон хэлтэй боловсон хүчнийг хуучин ЗХУ-д бэлтгэхийн зэрэгцээ, Монгол улсын их сургуульд 1975 оноос япон хэлний сургалт явуулж эхэлсэн нь хүрээлэнгийн япон судлаачдын эгнээг өргөтгөхөд ач холбогдолоо өгсөн чухал ажил байв. Дорнодахины судлалын хүрээлэн 80-аад онд япон хэлтэй залуучуудаа Япон улсад хэлний мэргэжил дээшлүүлэгч, судлаач оюутнаар суралцуулж байсан нь Япон судлал өргөжихөд нөлөөлсөн билээ.

1980-аад оны сүүлчээр дэлхий дахины олон улсын амьдралд гарсан үндсэн эргэлт, Монгол улсад өрнөсөн ардчилал шинэчлэлт нь манай улсын гадаад харилцааг үндсээр нь өөрчилж, олон тулгуурт, нээлттэй гадаад бодлого хэрэгжиж эхэлснээр Монгол-Японы харилцаа шинэ үе шатанд дэвшин, эрс идэвхжиж үсрэнгүй хурдацтай хөгжиж эхэлсэн юм. Энэ шинэ нөхцөлд Дорнодахины судлалын хүрээлэнгийн япон судлалын ажлын хүрээ урьд өмнөхөөс өргөжин тэлж, судалгааны ажил Япон дахь монгол судлалын зэрэгцээ Монгол, Японы харилцаа, Японы хөгжлийн туршлага, Япон орон судлалын чиглэл руу хандах боллоо. Хүрээлэнгийн залуу судлаачдын хамтын бүтээл “Япон орон, япончууд” хэмээх жижиг товхимол 1990 онд хэвлэгдлээ.

90-ээд оноос Монгол-Японы харилцааны судалгаанд нэлээд ахиц гарсан гэж хэлж болох юм. Зүүн Хойт Ази судлалын төвийн эрдэмтэд судлаачдын бичиж нийтлүүлсэн “Монгол-Японы харилцаа: эрт, эдүгээ” /УБ.1998/ эрдэм шинжилгээний өгүүллийн эмхэтгэл нь манай улсад Монгол-Японы харилцааны сэдвийг дагнан авч үзсэн анхны эрдэм шинжилгээний хамтын бүтээл болсон бөгөөд хоёр орны харилцааы түүх, орчин үеийн байдал, хамтын ажиллагааны төлөв, цаашдын чиг хандлагыг тусгасан судалгааны өгүүллүүд орсон юм.

Түүхийн шинжлэх ухааны доктор Ц.Батбаяр “Монгол ба Япон: XX зууны эхэн хагаст” /УБ. 1998/ хэмээх эрдэм шинжилгээний дорвитой бүтээл туурвиж, нийтийн хүртээл болголоо. Доктор Ц.Батбаяр судалгаандаа XX зууны эхэн хагасын Монгол-Япон-Зөвлөлт-Хятадын хоорондын харилцааны хувьсал өөрчлөлт, ээдрээ төвөгтэй мөчүүдийг задлан шинжилж, Монгол улсын тусгаар тогтнолын асуудалд Монгол-Японы харилцаа, ялангуяа Японы хүчин зүйл хэрхэн нөлөөлж ирснийг Монгол, Орос, Япон, Хятад зэрэг орны урьд өмнө судалгааны эргэлтэд ороогүй архивын материал хэрэглэгдэхүүнд тулгуурлан үнэлэлт дүгнэлт өгснөөрөө энэ бүтээл Монгол-Японы харилцааны судлал төдийгүй Монголын түүх судлалд жинтэй хувь нэмэр оруулсан цоо шинэ бүтээл болсон билээ.

XX зууны Монгол-Японы харилцааны сүүлийн 50 жилийн түүхийг судалж, Б.Сэржав “Монгол-Японы харилцаа: XX зууны сүүлийн хагаст” нэгэн сэдэвт зохиол бичжээ. Судлаач хоёр орны харилцааны хөгжлийн түүх, агуулга, шинж чанар, орчин үеийн чиг хандлага, ирээдүйн төлөв байдал, зэрэг олон талт асуудлыг эрдэм шинжилгээний үүднээс судлан дүгнэх оролдлого хийжээ.

Түүнчлэн хүрээлэнгийн судалгааны төслүүдийн үр дүнд нийтлэгдсэн “Япон, Азийн “барс” үсрэнгүй хөгжсөн нь” /УБ. 1994/, “Зүүн хойт Ази: эдийн засгийн хамтын ажиллагаа” /УБ.1995/, “1990-ээд оны олон улсын харилцааны хандлагууд, Монгол улс, их гүрнүүдийн харилцаа” /УБ. 1995/, “Монгол Улс ба Зүүн хойт Ази” /УБ, 2002/ зэрэг хамтын бүтээлүүдэд Япон улс болон шинээр аж үйлдвэржсэн улс, бүс нутгийн үсрэнгүй хөгжлийн туршлага, Монгол улсаас Зүүн хойт Азийн бүс нутгийн болон бусад улсуудтай тогтоосон хоёр ба олон талт хамтын ажиллагааны байдал, түүнийг цаашид хэрхэн хөгжүүлэх, гадаад орчин, гадаад харилцаа хамтын ажиллагааг хэрхэн ашиглах боломжуудыг сүвэгчлэн бичсэн нь тус хүрээлэнгийн Япон судлалын ажлын хүрээ хэмжээ сүүлийн жилүүдэд өргөжин тэлж буйг харуулж байгаа юм.

Сүүлийн үед академич Т.Намжимийн “Япон орон тоймлон харвал” /УБ.1998/, доктор Т.Мөнхцэцэг “Япон дахь Монголын түүхийн судалгаа” /УБ. 2000/ зэрэг нэгэн сэдэвт бүтээлүүд, Монгол, Японы харилцааг дэмжих Түншийн холбоо нийгэмлэг “Монгол Японы харилцаа: эрт, эдүгээ” /УБ. 2001/ зэрэг олон бүтээлүүд гарлаа. Түүнчилэн, Япон орны нийгэм, эдийн засаг, түүх, соёл, Японы ард түмний амьдрал ахуйг Монголын ард түмэнд сурталчлан танилцуулахад чиглэсэн судалгаа, сурталчилгааны олон тооны өгүүлэл, япон хэл суралцагсдад зориулсан япон хэлний сурах бичиг, толь бичиг, гарын авлагууд хэвлэгдэн гарсаар байна. Сүүлийн үед их сургуулиудын эрдэмтэн багш нар, судалгааны хамтлаг, олон нийтийн байгууллагуудад япон судлалыг сонирхон судалдаг хүмүүсийн эгнээ өргөжиж, япон хэл суралцагч оюутан, сурагчдын тоо өссөөр ирсэн нь япон судлалд ахиц дэвшил гарахад чухал нөлөө үзүүлэх нь дамжиггүй.

Олон улсын судлалын хүрээлэнгийн Япон судлалын тасаг одоо “Азийн бүс нутгийн интеграци: Монголын хөгжлийн зарим асуудал”, “Монгол Японы эдийн засгийн хамтын ажиллагаа (одоо, ирээдүй)” зэрэг сэдвүүдээр судалгаа явуулж байна. Цаашид Япон улс судлалыг орчин үеийн орон судлалын шаардлагад нийцүүлэн явуулах, эрдэм шинжилгээний арга зүйг боловсронгуй болгох, хүрээлэнг япон судлалын боловсон хүчнээр бэхжүүлэх, эрдэм шинжилгээний ажилтнуудын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, хоёр ард түмний харилцан ойлголцол, итгэлцэл, найрсаг харилцааг гүнзгийрүүлэх, Япон улстай тоогтоосон бүх талын хамтын ажиллагааг бэхжүүлэн хөгжүүлэхэд тус дэм үзүүлэх зорилт тавин ажиллаж байна.